



НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР,
АЙМГИЙН БОЛОВСОЛ, СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА НАРТ

**БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
ИНСТИТУТ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 10

Багшийн хөгжлийн ордон

Утас/Факс: (976) 7014-0069. www.itpd.edu.mn

2016.09.09 № 1/193
танай _____-ны № _____-т

Онлайн сургалт, мэргэжлийн шалгалтыг
давтан зохион байгуулах тухай

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/305 дугаар тушаалаар батлагдсан “Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2, болон 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багшлах эрх олгуулах болон сунгуулах хүсэлт гаргасан багш нарт зориулсан онлайн сургалт, мэргэжлийн шалгалтыг Аймаг, Нийслэлд давтан зохион байгуулахаар төлөвлөөд байна. Үүнд:

- 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд онлайн сургалт
- 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр мэргэжлийн шалгалтыг тус тус зохион байгуулна.

Иймд онлайн сургалт болон мэргэжлийн шалгалтыг давтан зохион байгуулах удирдамжийн дагуу бидэнтэй хамтарч ажиллана уу.

Онлайн сургалт болон мэргэжлийн шалгалтыг давтан зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж болон шалгуур үзүүлэлт хангаагүй багш нарын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралтад заагдсан багш нарыг онлайн сургалт болон мэргэжлийн шалгалтыг давтан зохион байгуулахад оролцуулах шаардлагатай тухай мэдэгдлийг уг багш нарын ажиллаж буй ЕБС, цэцэрлэгүүдэд хүргэнэ үү.

Дэлгэрэнгүй мэдээллийг info@itpd.mn цахим шуудан болон 70140056, 77100056 утсаар лавлана уу.

Хавсралт 1: Удирдамж, .б... хуудастай.

Хавсралт 2: Багш нарын нэрс, хуудастай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



А.ТУЯА

000 00165